



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/77/СТА-ТШЗ



Баянхонгор 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: П.Мөнх-Эрдэнэ

Утас: 88045601 Цахим хаяг: munkherdenep@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	4
2	Аудитын тайлан	6
2.1	Оршил	6
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	7
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	7
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	8
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	9
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	9
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
	Байхгүй.	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал	12
3.1	Балансын данстай холбоотой асуудал.....	12
3.1.1	Илрүүлэлт:	12
3.1.2	Эрсдэл:.....	13
3.1.3	Өгсөн зөвлөмж:.....	13
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	13
3.2	Балансын данстай холбоотой асуудал.....	13
3.2.1	Илрүүлэлт	13
3.2.2	Эрсдэл.....	13
3.2.3	Өгсөн зөвлөмж.....	13
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	13
3.3	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл.....	13
3.3.1	Илрүүлэлт	13
3.3.2	Эрсдэл.....	13
3.3.3	Өгсөн зөвлөмж.....	14
3.3.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	14
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	15
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН ПОЛИТЕХНИКИЙН
КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ Д.БАТ-ОРШИХ ТАНАА

2019.08.25 № 2/52
танай _____-ны № _____-т

Г

Аудитын гэрчилгээ

Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн

2515085

хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Д.Бат-Орших-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.22-нээс 2019.01.23–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.01.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Мөнх-Эрдэнэ хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Политехникийн коллеж 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдрийн 35 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Политехникийн коллеж нь “Баялаг бүтээгч чадамжтай төгсөгчдийг бэлтгэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймгийн Политехникийн коллеж удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Политехникийн коллеж санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Политехникийн коллеж санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Axplorer 3.16” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Политехникийн коллеж дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2018 оны үр дүнгийн нийт зардал 1786652,3 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 17866,5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Сая төгрөгөөр

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	9.9	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	0.8	
	Дүн	2	10.7	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад багш ажилтан нараас суутгалгүй цалингаас шилжүүлсэн хоолны төлбөр 853,0 мянган төгрөгийг авлагаар бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ Байхгүй.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Политехникийн коллеж чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1587,4 сая төгрөгийн төсөв

батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1532,6 сая төгрөг буюу 96,5 хувьтай байгаа нь төсөвт 51,0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн ба энэ нь дотуур байрны хүүхдийн тоо буурсантай холбоотойгоор хоолны төсөв 48,4 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Политехникийн коллеж нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Политехникийн коллеж 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Илрүүлэлт:

Авлагын дансны хувьд байрны хүүхдийн хоолны тендерийг оны дараа зарладаг учраас Бүдүма ХХК-д 4,1 сая төгрөгийг илүү шилжүүлсэн.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.8 дахь "...тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх." тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Байрны хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг өмнөх оны 12 сард багтаан холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Саналгүй

3.2 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.2.1 Илрүүлэлт

Жолоооны төлбөрийн авлагыг 2,6 сая төгрөгөөр барагдуулсан нь хангалтгүй үр дүнтэй байна.

Энэ нь “Эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл

Өр төлбөрийг төлөх үүргээ суралцагч биелүүлэхгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж

Урьд онуудаас хуримтлагдаж ирсэн жолоооны төлбөрийн авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлж, шүүхийн байгууллагад шилжүүлж тооцоог барагдуулах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Саналгүй.

3.3 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

3.3.1 Илрүүлэлт

Уралдаан тэмцээнд амжилт гарган оролцсон багш, ажилтан нарт цалингийн сангаас урамшуулал олгосон.

Энэ нь “Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь” батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах.

3.3.3 Өгсөн зөвлөмж

Цалингийн сангаас уралдаан тэмцээнтэй холбоотой урамшуулал олгохгүй байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Саналгүй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	289334151.01	381770989.01
33	АВЛАГА	12750000.00	30978044.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	900000.00	2805000.00
335	Бусад авлага	11850000.00	28173044.00
3351	Байгууллагаас авах авлага	0.00	17568044.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	11850000.00	10605000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	276584151.01	350792945.01
351	Түүхий эд материал	207511786.01	245256777.01
35110	Тусгай зориулалттай материал	207511786.01	244761777.01
35130	Эм боох материал	0.00	495000.00
354	Хангамжийн материал	69072365.00	105536168.00
35410	Бичиг хэргийн материал	6864931.00	8877450.00
35420	Аж ахуйн материал	55300634.00	72575024.00
35450	Барилгын засварын материал	6906800.00	19370100.00
35460	Хүнсний материал	0.00	4713594.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1077260246.63	2977114519.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1077260246.63	2977114519.90
392	Биет хөрөнгө	1065452746.61	2185913686.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	2218514992.00	1427356357.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	1990597806.75	-9959998.89
39203	Авто-тээврийн хэрэгсэл	174980800.00	174980800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-72843614.92	-91480104.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1362738685.42	1468866394.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	-778181134.90	-945774211.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	283004601.23	320417746.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	-213085961.37	-240334106.63
39214	Бусад үндсэн хөрөнгө	0.00	19878953.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-19188329.07
39217	Ном	80922185.90	81150185.90
393	Биет бус хөрөнгө	11807500.02	791200833.36
39301	Програм хангамж	18010735.00	18010735.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6203234.98	-7909901.64
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	78110000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1366594397.64	3358885508.91
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	978000.00	30000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	978000.00	30000.00
413	Өглөг	978000.00	30000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	978000.00	0.00
4136	Бусад өглөг	0.00	30000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	30000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1365616397.64	3358855508.91
51	Засгийн газрын хувь оролцоо	1365616397.64	3358855508.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1164134164.54	1945234164.54
51101	Өмч: - төрийн	1164134164.54	1945234164.54
512	Хуримтлагдсан үр дүн	-254635095.68	-57811702.63
51210	Өмнөх үеийн үр дүн	-254635095.68	-69514784.58
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	11703081.95

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	456117328.78	1471433047.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1366594397.64</u>	<u>3358885508.91</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1715128980.00	1798355349.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	162141392.00	157465875.00
120	Нийтлэг татварын бус орлого	162141392.00	157465875.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	162141392.00	157465875.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	44274157.00	26057760.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	117867235.00	131408115.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1552987588.00	1640889474.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1508349100.00	1556418600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1508349100.00	1556418600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31491000.00	72984984.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	31491000.00	25360084.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	47624900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13147488.00	11485890.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	13147488.00	11485890.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1763171903.14	1786652267.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1763171903.14	1786652267.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1646547458.14	1666472173.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	794533430.00	813735852.00
210101	Үндсэн цалин	794533430.00	813735852.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91523570.00	97883634.00
210201	Тэтгэврийн даатгал	91523570.00	97883634.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	304335700.00	322647542.00
210301	Гэрэл, цахилгаан	13336058.00	19583692.00
210302	Түлш, халаалт	278784000.00	286895598.00
210303	Цэвэр, бохир ус	12215642.00	16168252.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16653838.00	16153545.00
210401	Бичиг хэрэг	5972475.00	4408481.00
210402	Тээвэр, шатахуун	4166374.00	2899404.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3270164.00	4505600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2201525.00	1666000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1043300.00	2674060.00
2105	Нормативт зардал	85099244.00	42610342.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	495000.00	0.00
210502	Хоол, хүнс	74628436.00	42610342.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9975808.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23972300.00	28948000.00

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	23972300.00	28948000.00
2107	Томилолт, зочны зардал	4252200.00	4135800.00
210702	Дотоод албан томилолт	4252200.00	4135800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9275200.00	14192200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5197500.00	3892200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	3000000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4077700.00	7300000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	316901976.14	326165258.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	71060822.00	81069323.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	245841154.14	245095935.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	116624445.00	120180094.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	114260288.00	69094290.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	13147488.00	11485890.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22122800.00	34450200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50790000.00	23158200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28200000.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2364157.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2364157.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	51085804.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	51085804.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-48042923.14</u>	<u>11703081.95</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	39805637.51	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	39805637.51	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-39805637.51	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-87848560.65</u>	<u>11703081.95</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1585751745.00</u>	<u>1620567334.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>32764157.00</u>	<u>27302760.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	32764157.00	27302760.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32764157.00	27302760.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32764157.00	27302760.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>1552987588.00</u>	<u>1593264574.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1508349100.00	1556418600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1508349100.00	1556418600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31491000.00	25360084.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	31491000.00	25360084.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13147488.00	11485890.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	13147488.00	11485890.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1584331745.00</u>	<u>1610698588.00</u>

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

21	УРСГАЛ ЗАРДАЛ	1584331745.00	1610698588.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1467707300.00	1490518494.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	799611700.00	816033586.00
210101	Үндсэн цалин	688268700.00	652738586.00
210102	Нэмэгдэл	54319000.00	112211000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57024000.00	51084000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87967300.00	98438900.00
210201	Тэтгэврийн даатгал	87967300.00	98438900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	304335700.00	322587542.00
210301	Гэрэл, цахилгаан	13336058.00	19523692.00
210302	Түлш, халаалт	278784000.00	286895598.00
210303	Цэвэр, бохир ус	12215642.00	16168252.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22461100.00	17461100.00
210401	Бичиг хэрэг	9207500.00	5104600.00
210402	Тээвэр, шатахуун	4234960.00	4167000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4636664.00	4505600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4381976.00	3683900.00
2105	Нормативт зардал	93976300.00	58115928.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	495000.00	495000.00
210502	Хоол, хүнс	81561300.00	47700928.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11920000.00	9920000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8583300.00	35363300.00
210604	Урсгал засвар	8583300.00	35363300.00
2107	Томилолт, зочны зардал	4252200.00	4135800.00
210702	Дотоод албан томилолт	4252200.00	4135800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9275200.00	15297500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5197500.00	4997500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	3000000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4077700.00	7300000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	137244500.00	123084838.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	137244500.00	123084838.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	116624445.00	120180094.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	114260288.00	69094290.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	13147488.00	11485890.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22122800.00	34450200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50790000.00	23158200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28200000.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2364157.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2364157.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	51085804.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	51085804.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1420000.00	9868746.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1420000.00	9868746.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1420000.00	9868746.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1420000.00	9868746.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1420000.00	9868746.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1420000.00	-9868746.00

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,164,134,164.54	456,117,328.78	-254,635,095.68	1,365,616,397.64
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,164,134,164.54	456,117,328.78	-254,635,095.68	1,365,616,397.64
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,164,134,164.54	456,117,328.78	-254,635,095.68	1,365,616,397.64
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,164,134,164.54	456,117,328.78	-254,635,095.68	1,365,616,397.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	185,120,311.10	185,120,311.10
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,164,134,164.54	456,117,328.78	-69,514,784.58	1,550,736,708.74
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	1,015,315,718.22	0.00	1,015,315,718.22
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	781,100,000.00	0.00	0.00	781,100,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	11,703,081.95	11,703,081.95
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,945,234,164.54	1,471,433,047.00	-57,811,702.63	3,358,855,508.91

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1539349100.00	1541113257.00	1587418600.00	1532635556.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1539349100.00	1541113257.00	1587418600.00	1532635556.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1437636300.00	1437636300.00	1529810200.00	1475027156.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	799611700.00	799611700.00	820326100.00	816033586.00
210101	Үндсэн цалин	688268700.00	688268700.00	654639300.00	652738586.00
210102	Нэмэгдэл	54319000.00	54319000.00	114602800.00	112211000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57024000.00	57024000.00	51084000.00	51084000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87967300.00	87967300.00	98438900.00	98438900.00
210201	Тэтгэврийн даатгал	87967300.00	87967300.00	98438900.00	98438900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	304335700.00	304335700.00	324523600.00	322587542.00
210301	Гэрэл, цахилгаан	13919500.00	13336058.00	21240800.00	19523692.00
210302	Түлш, халаалт	278784000.00	278784000.00	286895600.00	286895598.00
210303	Цэвэр, бохир ус	11632200.00	12215642.00	16387200.00	16168252.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22461100.00	22461100.00	17461100.00	17461100.00
210401	Бичиг хэрэг	9207500.00	9207500.00	4207500.00	5104600.00
210402	Тээвэр, шатахуун	4544100.00	4234960.00	4544100.00	4167000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4922800.00	4636664.00	4922800.00	4505600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3786700.00	4381976.00	3786700.00	3683900.00
2105	Нормативт зардал	93976300.00	93976300.00	106554000.00	58115928.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн	495000.00	495000.00	495000.00	495000.00

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	хэрэгсэл				
210502	Хоол, хүнс	81561300.00	81561300.00	96139000.00	47700928.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11920000.00	11920000.00	9920000.00	9920000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал				
		8583300.00	8583300.00	35583300.00	35583300.00
210604	Урсгал засвар	8583300.00	8583300.00	35583300.00	35583300.00
2107	Томилолт, зочны зардал				
		4252200.00	4252200.00	4252200.00	4135800.00
210702	Дотоод албан томилолт	4252200.00	4252200.00	4252200.00	4135800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж				
		9275200.00	9275200.00	15497500.00	15497500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5197500.00	5197500.00	5197500.00	5197500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	0.00	3000000.00	3000000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4077700.00	4077700.00	7300000.00	7300000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал				
		107173500.00	107173500.00	107173500.00	107173500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	107173500.00	107173500.00	107173500.00	107173500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
		101712800.00	103476957.00	57608400.00	57608400.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг				
		0.00	2364157.00	0.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		2364157.00		
2132	Бусад урсгал шилжүүлэг				
		101712800.00	101112800.00	57608400.00	57608400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22122800.00	22122800.00	34450200.00	34450200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50790000.00	50790000.00	23158200.00	23158200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28800000.00	28200000.00	0.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР				
		1539349100.00	1541113257.00	1587418600.00	1532635556.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
		1508349100.00	1508349100.00	1556418600.00	1505332796.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1508349100.00	1508349100.00	1556418600.00	1505332796.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
		31000000.00	32764157.00	31000000.00	27302760.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31000000.00	32764157.00	31000000.00	27302760.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
		96.00	96.00	96.00	96.00
620001	Удирдах ажилтан	4.0	4.0	4.0	4.0
620002	Гүйцэтгэх ажилтан	74.0	74.0	74.0	74.0
620003	Үйлчлэх ажилтан	18.0	18.0	18.0	18.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)				
		965.00	965.00	965.00	965.00
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ				
		965.00	965.00	965.00	965.00
632001	Төрийн өмчит МСҮТ	965.00	965.00	965.00	965.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				
		96.0	96.0	96.0	96.0
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	65.0	65.0	65.0	65.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	31.0	31.0	31.0	31.0